



ARURA
ORGANICS

АРУРА ОРГАНИКС

МЭНДЧИЛГЭЭ

ХҮНДЭТ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТАНАА,

Хэрвээ та манай бүтээгдэхүүнийг сонирхож, сонгон авч байгаа бол бидэнд ижил төстэй зүйл байна.

Та бид өөрсдийн бие махбод, оюун санаа, гэр бүл, ажил хөдөлмөр, идэж буй хоол унд зэрэгтээ илүү анхаарал тавьж байгаагаараа ижил төстэй хүмүүс юм.

Бид таныг өөрийнхөө амьдарч буй цаг хугацаандаа хүндэтгэлтэй хандаж байгаа хүн гэдгээр нь тань байхархаж байна.

Иймээс манай баг хамт олон эрүүл органик зүйлийг сонгон хэрэглэглэдэг үйлчлүүлэгч нартаа зориулж бүтээгдэхүүн бүрээ хайр энэрэлээр дүүрэн урлаж хийдэг билээ.

ТАНД АЗ ЖАРГАЛ, ЭРҮҮЛ ЭНХИЙГ ХҮСЬЕ.

Хүндэтгэсэн,

Ц.Есөн-Эрдэнэ Компанийн үүсгэн байгуулагч

Б.Нармандах Гүйцэтгэх захирал

“Арура органикс” брэндийн баг хамт олон

АЛСЫН ХАРАА

БАЙГАЛИЙН ШИЙДЭЛ

Таны эрүүл мэндийн асуудлыг байгалийн эмчилгээнд түшиглэн аюулгүй, үр дүнтэй, хүртээмжтэй аргаар шийднэ.



БАЙГАЛЬД ДУРЛАХ

Байгаль эх бидэнд маш ховор нандин анагаах чадалтай ургамлын зүйлсийг бэлэглэсэн. Хүмүүс ургамлын эмчилгээний гайхамшигийг мэдэрч байгальдаа эргэн дурлаж эхэллээ.

Бид уламжлалт анагаах ухааны ургамлын эмчилгээнд түшиглэн хүн төрөлхтнийг эрүүл мэндээ хамгаалахад туслах, арга ухааныг заан сургах зорилготой.





УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ШИНЭ ЭРИН

Монголчууд бид өнө эртний анагаах ухааны өв уламжлалтай. Ургамлын эм нь ихэвчлэн нунтаг хуурай хэлбэртэй, бага зэрэг гашуун амттай байдаг. Тэгвэл бид ургамлын эмийг хүний өдөр тутмын хоол хүнсний болон ахуйн хэрэгцээнд нийцүүлэн шингэн, тосон, усан хэлбэрт оруулж ууж хэрэглэхэд таатай амттай байхаар өөрчлөн хөгжүүлж, орчин цагийн шинжлэх ухааны арга барилд нийцүүлэн гаргаж ирсэн нь давуу тал юм.

ЭРҮҮ АМЬДРАЛ - УРГАМЛЫН АМЬДРАЛ

Ургамлын эмчилгээ бол бидний өдөр тутмын амьдралын салшгүй нэг хэсэг.

Тиймээс эрүүл амьдрахын тулд “Өдөр тутмын амьдрал”-аа - Ургамлын амьдрал”-тай хослуулах нь цор ганц шийдэл юм.



ЭРХЭМ ЗОРИЛГО



БИДНИЙ УРИА

Аюулгүй, үр дүнтэй, органик эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг бий болгох

БИДНИЙ МЕНЕЖМЭНТ

Уламжлалт анагаах ухаан бол 5000 жилийн түүхтэй эрүүл мэндийн тогтолцоо бөгөөд тэр чигтээ амьдралын шинжлэх ухаан, урт наслах ухаан юм.

Орчин үеийн амьдралын хэв маяг, байгаль орчны өөрчлөлт, хоол тэжээлийн нөхцөл байдал маш хортой болж байгаа энэ үед аливаа өвчин зовиур, бэрхшээлийг даван туулахын тулд ургамлын анагаах ухаанд суурилсан “Арура органикс” брэндийг бий болгосон юм.

Уламжлалт анагаах ухааны үзэл баримтлал, оношлогоо, эм эмчилгээг хамгийн дээд түвшинд жинхэнэ утгаар нь хэрэгжүүлж байгаа нь бидний амжилтын нууц юм.

Та өөрийгөө хайрладаг, өөртөө цаг зав гаргадаг хүн байх ёстой. Тиймээс бид таныг халамжлах бүхий л зүйлсийг урлаж байна.

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ

ТАНИЛЦУУЛГА





УРГАМЛЫН ХАНД

Олон төрлийн ургамлын үндэс, иш, навч, цэцэг, үр зэргийг ашиглан шингэн ургамлын хандыг орчин үеийн дэвшилтэт техник технологиор өндөр үр дүнтэй аюулгүй, гаж нөлөөгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Тухайлбал: Хоргүйжүүлэх, сахарын эсрэг, шингээлтийг сайжруулах, тураах, эмэгтэйчүүдийн тэжээл, эрэгтэйчүүдийн тэжээл, элэг хамгаалах, бөөр хамгаалах гэх мэт ургамлын ханд бэлтгэж байна.

Ургамлын шингэн ханд нь хорт бодис агуулаагүй, ямарч насны хүн хэрэглэхэд тохиромжтой байхаар үйлдвэрлэгдсэн. Энэхүү ургамлын бэлдмэл нь өвөрмөц амт, байгалийн үнэр, ургамлын хамгийн цэвэр хэлбэрийн шингэн хольц юм.



УРГАМЛЫН ДАРС

Олон төрлийн ургамлын үндэс, иш, навч, цэцэг, үрийг ашиглан дарс нэрэх уламжлалт технологийг ашиглан эмчилгээний дарсыг таны таашаалд нийцүүлэн бүтээж байна.

УРГАМЛЫН ЦАЙ



Бид гурван үрийн хоргүйжүүлэх цай, дархлаа дэмжих цай, эмэгтэйчүүдийн цай, хөхний сүү оруулагч цай, нойргүйдлийн цай, тураах цай, хийн цай, шарын цай, бадганы цай гэсэн бүтээгдэхүүнийг танд санал болгож байна.

ГУРВАН ҮРИЙН ЦАЙ



Найрлага: Арур, Барур, Жүрүр, зөгийн бал

Цай бол бидний хоолны дэглэмийн чухал хэсэг юм. Бид ихэвчлэн цайг кафейн агуулсан хэлбэрээр хэрэглэдэг боловч эрүүл мэндэд тустай кафейны агууламжгүйг төдийлөн сонгож мэдэдгүй. Эрүүл мэндийн цайнд цэвэр ургамлын гаралтай эсвэл ногоон цай ордог.

Гурван үрийн цай нь хоол боловсруулахад маш сайн нөлөөтэй бөгөөд бага зэргийн тайвшруулах үйлчилгээ үзүүлдэг. Өтгөн хаталтыг намдаана. Цайнд агуулагдах жүрүр нь ходоодны үрэвслээс урьдчилан сэргийлэхэд тусалдаг.

Мөн дархлааг сайжруулна. Халдварт өвчнөөс хамгаалах антиоксидантаар баялаг байдаг. Биед хуримтлагдсан өөх тосыг задалж, жингээ хасахад тусална. Бие махбодид шим тэжээлийг зөв шингээж өгдөг.

Энэхүү цайг усанд найруулж өглөө ууж хэрэглэх нь илүү тохиромжтой. Унтахынхаа өмнө гурван үрийн цай уух нь тайван унтахад тусалдаг ч зарим хүмүүст шээс хөөх шинж чанартай байдаг тул шөнийн цагаар босох шаардлага гардаг.





ДАРХЛАА ДЭМЖИХ ЦАЙ



Найрлага: Цагаан гаа, улаан чавга, улаан үзэм, арур, барур, жүрүр, шинц модны холтос, одон гоньд, шар гаа, ногоон сүгмэл, гүргүм өвс, гүнжидийн үр, бурам, зөгийн бал

Дархлаа дэмжих цайны өвөрмөц найрлагууд нь маш нарийн зохицол, уялдаа холбоотойгоор бүтээгдсэн.

Фито-элемент гэж нэрлэгддэг өөр өөр ашигтай бүрэлдэхүүн хэсгүүдийн холимог агуулсан учир ургамлууд болон бусад бүрэлдхүүн хэсгүүдийг хамтад нь хэрэглэх нь хүчтэй антиоксидант, бактерийн эсрэг, вирусын эсрэг, стрессийн эсрэг, дархлааг сайжруулах шинж чанартайгаас гадна ерөнхий эрүүл мэндийг дэмжиж, бие махбодийг халдвар, стрессээс ангид байлгах байгалийн хамгаалалтын үүрэгтэй юм.

Цай нь өвөрмөц зөөлөн, бага зэрэг халуун амттай тул сэтгэл сэргээдэг. Энэхүү цай нь үнэ цэнэтэй шим тэжээлийн өндөр эх үүсвэр юм.

ХИЙН ЦАЙ



*Найрлага: Задь, чихэр өвс, ногоон сүгмэл,
шинц модны холтос, цагаан гаа, бурам*

Хийн цай нь гайхалтай амттай бөгөөд бидний бие дэх хийн элементийг тэнцвэржүүлж өгнө. Энэхүү цайны орц найрлагад байгаа ургамлууд нь хоол болосруулах хөдөлгөөнийг зохицуулдаг хийн ажиллагааг тэнцвэржүүлэхээс гадна хоол хүнсний хэрэггүй хэсгийг биеэс гадагшлуулах хөдөлгөөнийг идэвхижүүлж өгдөг. Ялангуяа ходоод дүүрч цанхайх, өтгөн хатах, гэдэс базлах, гүйлгэх, хоол шингэхгүй байх зэрэгт тохиромжтой. Энэ бол органик амтлагч, эмийн ургамлаар хийсэн каффейны агууламжгүй цай юм.

ШАРЫН ЦАЙ



Найрлага: Сарнай, хонин
нүдэн цэцэг, пеперминт,
кумин, кориандар

Шарын цай нь хэт халсан бие, оюун ухаан, сэтгэл хөдлөлийг хөргөж, тайвшруулдаг. Мэдрэлийн системийг сэргээж, тайвшруулж, тэжээл өгөх органик цэцэг, ургамлуудаас бүрдсэн тааламжтай амтат кафейнгүй цай юм.

БАДГАНЫ ЦАЙ



Найрлага: Цагаан
гаа, турмерик,
фенугрек үр, ногоон
сүгмэл, хадаасан
цэцэг



Бадганы цай нь биеийг дулаацуулах, хоол боловсруулалтыг идэвхжүүлж, салстын түгжрэлийг цэвэрлэж, бие махбод, оюун санааг сэргээж, бат бөх, сэтгэл ханамжтай болгодог ургамлуудаас бүрдсэн. Кафейны агууламжгүй 100% органик цай юм.



АНАГААГЧ УС

Усыг дангаар нь бус амталж уух нь шим тэжээлийн эх үүсвэр болдог. Та дараах ургамлуудыг өөрийн биеийн байдал, хүсэл сонирхолдоо нийцүүлэх авч усаа амталж ууж хэвшээрэй.



ШАНЦ МОДНЫ ХОЛТОСТ УС

Хоол боловсруулах үйл явцыг дэмжиж, цусан дах сахарын түвшинг бууруулна. Нян, үрэвслийн эсрэг чанартай тул биеэс хор гадагшлуулж, шүд амны хөндий болон амьсгалын эрхтэн тогтолцооны эмгэгүүдэд сайнаар нөлөөлнө.

КОРИАНДЭРИЙН УС

Чихрийн шинжингийн үед ам цангах зовиургыг багасгана. Нянгийн эсрэг үйлдэлтэй тул амны хөндийн шархлаат эмгэгийн үе дэх зовиургыг намдаана. Хүчтэй антиоксидант чанартай. Хаван бууруулах нөлөө үзүүлнэ.



ГҮРГЭМ ЦЭЦГИЙН УС

Хорт хавдрын эсрэг, ой санамжийг сэргээх, эрч хүчийг нэмэгдүүлэх ба бэлгийн сулрал, үс халзрах эмгэг болон ханиад томууны үед сайн нөлөөтэй.



НОГООН СҮГМЭЛТ УС

Хоол боловсруулалт дэмжих, хоргүйжүүлэх, бөөр шээсний замыг цэвэрлэх, сэтгэл гутралын эсрэг, бактер, мөөгөнцөр, вирус, үрэвсэл, шарх, хавдрын эсрэг нөлөө үзүүлнэ.



ХАДААСАН ЦЭЦГИЙН УС

Антиоксидант чанар өндөр, хавдрын эсрэг, бактерийн эсрэг, элэгний ажиллагааг дэмжин, цусан дах сахарын түвшинг бууруулж, яс үе мөчийг бэхжүүлж, ходоодны хавдрын эсрэг нөлөө үзүүлнэ.

ГОНЬДТОЙ УС

Гоньдны үр нь биеэс илүүдэл ус, өөх тос, хорыг гадагшлуулдаг бөгөөд бага зэрэг шээс хөөх үйлдэл үзүүлнэ. Хоол боловсруулах системийг айжруулж, даралт ихсэх, чихрийн шижин өвнөөс урьдчилан сэргийлнэ. Мэдрэлийн системийг тайвшруулж, мелатонины үйлдвэрлэлийг дэмжиж дотоод шүүрлийг системийг сайжруулна. Элэг цөсний эмгэгээс үүдэлтэй дотор өөхлөлт болон таргалатаас урьдчилан сэргийлнэ.



ШАР ГААТАЙ УС

Шар гаатай ус тогтмол уух нь дархлааны тогтолцоог тэнцвэржүүлж цусан дах холестериньг багасгаж, чихрийн шижин, судас хатуурах эмгэг, зүрхний шигдээс, элэг цөс, үе мөч, арьсны үрэвсэл халдвараас урьдчилан сэргийлдэг. Ялангуяа

өвлийн улиралд уух нь ханиад томуунаас сэргийлж өгдөг. Мөн тархины эд эсийг хамгаалж, хорт хавдрын эрсдлийг бууруулдаг.



КАССИА ҮРТ УС

Кассиа үрийн ус нь дархлаа сэргээн, гэмтсэн эд эсийг сэргээх ба элэг цөсөн дэх хорт бодисыг шээс хөөх замаар биеэс гадагшлуулна. Тураах, жин бууруулах үйлчилгээтэй.





Шар тос бол эрүүл, органик тос бөгөөд монгол хүний хоол тэжээлийн чухал нэг хэсэг юм. Шар тосыг бид өдөр тутмын хүнсэнд болон эмчилгээний зориулалтаар хэрэглэж болно. Уламжлалт анагаах ухаанд эрт дээр үеэс шар тосыг залуужуулах, хүч тамир сэлбэх эмчилгээнд өргөн хэрэглэж ирсэн. Барууны шинжлэх ухаан саяханаас л энэхүү шимт тосны олон давуу талыг олж илрүүлээд байгаа. Харин олон мянган жилийн туршид бидний өвөг дээдэс ач тусыг нь мэдэн хэрэглэсээр ирсэн нь баттай үр дүн юм.



Арура органикс брэндийн хамгийн шилдэг бүтээгдэхүүний нэг нь ЭМТ ШАР ТОС юм.

Бидний шинэ бүтээлийн онцлог бол шар тос, зөгийн бал, эмийн ургамлын холимог бүхий хүнсний нэмэлт тэжээл юм. Шар тосыг ургамлын хандтай хослуулан хэрэглэснээр бие махбодыг шимжүүлж, насыг уртасгах, эрүүл амьдрахад нөлөөлөх болно.

Монгол орны байгалийн эрүүл цэвэр орчинд ургасан эмийн ургамлууд, бэлчээрийн малын сүүнээс гарган авсан цэвэр шар тос, Монгол орны цэвэр цэцгийн зөгийн бал зэрэг 100% органик орц найрлагатай, химийн өнгө будаг, хадгалагч бодис агуулаагүй бүтээгдэхүүн гэдгээрээ шинэлэг бөгөөд онцлог юм.



ЭМТ ШАР ТОСНЫ ТӨРӨЛ

Бид чихэр өвс-шар тосны холимог, 3 үр - шар тосны холимог, нишинг-шар тосны холимог, 5үндэс-шар тосны холимог, гүргүм өвс-шар тосны холимог, гоньд-шар тосны холимог гэсэн 6 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

НИШИН- ШАР ТОС

Эмэгтэйчүүдийн тэжээл гэж хэлж болно. Цус төлжүүлэх, сарын тэмдгийн хам шинж, нөхөн үржихүйн ажиллагааг дэмжинэ. Төрсний дараа хөхний сүү оруулахад үр дүнтэй. Жирэмсний 8 сараас эхлэн хэрэглэхэд тохиромжтой.

3 ҮР- ШАР ТОС

Цэвэрлэх, залуужуулах шинж чанартай. Цөсний суваг, цус, элгийг цэвэрлэнэ, гормоныг тэнцвэржүүлж, хоол боловсруулах чадварыг нэмэгдүүлэх ба бие махбодыг эд эсийн түвшинд сэргээнэ.

Витамин С болон антиоксидантаар баялаг учир хөгшрөлтийн эсрэг нөлөө үзүүлж, дархлаа дэмжин, арьс, үсийг эрүүлжүүлдэг.

ЧИХЭР ӨВС- ШАР ТОС

Амьсгалын болон шээсний замын эрхтнүүдийн үйл ажиллагааг дэмжинэ. Бөөрийг бэхжүүлж, шингэний урсгалыг хадгалахад тусална.

Чихэр өвс бол ходоодны салстыг зөөлрүүлж, илүүдэл цөсийг арилгаж тайвшруулна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нөхөн үржихүйн системд сайнаар нөлөөлдөг. Оюун санааг тайвшруулдаг.

ГОНЬД - ШАР ТОС

Мэдрэлийн систем, оюун ухаан, ой тогтоолт, анхаарал төвлөрлийг сайжруулахын зэрэгцээ мэдрэлийн системийн эмгэгийг эмчлэх хамгийн сайн хүнс тэжээл юм.

ЗАНГУУ - ШАР ТОС

Залуучуудыг хүч чадал, энерги, эрч хүч, дархлаа, булчингийн масс, бэлгийн чадавхийг нэмэгдүүлэх, эд эсийг нөхөн сэргээх чадварыг нэмэгдүүлдэг.

ГҮРГҮМ ӨВС-ШАР ТОС

Элэг, дэлүү, цөс, цус, нойр булчирхайд цэвэрлэгээ хийх, хоргүйжүүлэх үйлдэл үзүүлнэ. Энэ холимог нь сэрүүн чанартай тул үрэвсэл, батга, тууралт, дааврын тэнцвэргүй байдал, халууралт, үе мөчний үрэвсэл, элэгний эмгэг зэрэг шарын тэнцвэргүй байдлыг засах үйлчилгээтэй.

УРГАМЛЫН КОФЕ

Ихэнх хүмүүс сэтгэл санаа тавгүйтсэн үед юмуу стресст орсон үедээ кофег ихээр хэрэглэдэг. Гэвч кофе нь кафейны агууламж ихтэй байдаг учраас эрүүл мэндэд сайн биш юм.

Манай бүтээгдэхүүн хөгжүүлэлт, судалгааны баг хүмүүсийн өдөр тутмын хэрэглээ болох эмийн ургамлын найрлагтай кофег хэрэглээнд нэвтрүүлж эхлээд байна. Эдгээр бүтээгдэхүүн нь сахар, каффейн, синтетик нэмэлт, химийн хорт бодисын агууламжгүй гэдгээрээ онцлог. Ургамлын кофе нь кофены орлуулагч гэдгээрээ алдартай Чикори үндсээр хийгдсэн.

Ургамлын кофе нь дараах 4 төрлийн агууламжтай байна.




НОГООН СҮГМЭЛТЭЙ КОФЕ

Тархийг тайвшруулж,
стрессийг бууруулна.



НИШИНГТЭЙ КОФЕ

Эмэгтэйчүүд амьдралаас болон эрүүл мэндийн асуудлаас болж маш ихээр стресст өртдөг. Бид эмэгтэйчүүдийн эрүүл мэндтэй холбоотой өвчлөл болох дааврын өөрчлөлт, жингийн асуудал, даралт ихсэлт гэх мэт асуудлыг бууруулах зорилгоор Нишингний хольцтой кофег бүсгүйчүүддээ зориулж байна.





АРЬС, ҮС, БИЕ

АРЧИЛГАА

Бид байгалийн үнэрийг шингээсэн арьс, үс, биеийн гоо сайхны органик бүтээгдэхүүнийг санал болгож байна. Эдгээр бүтээгдэхүүнийг бэлтгэхэд хэрэглэдэг эмийн ургамлууд нь хортой химийн бодис, пестицид, бусад хорт бодисын агууламжгүй 100% аюулгүй байдаг учраас бүх насны хүмүүс хэрэглэхэд зориулагдсан.



100 ДАХИН ЦЭВЭРШҮҮЛСЭН ШАР ТОС



*Найрлага: Сарлагын
шар тос, зандан
модны охь тос, сарнайн ус*



Орц найрлага ба үйлдвэрлэлийн өвөрмөц технологи

100 дахин угаасан шар тос нь Уламжлалт анагаах ухааны эртний гоо сайхны жор найрлага бөгөөд тосоо бэлтгэн цэвэршүүлэх явц нь Буддын шашны тусгай тарни номын уншлага, зан үйлийн хамтаар хийгддэг маш өвөрмөц онцлогтой.

Монгол сарлагын сүүнээс шар тосыг ялган авч, сарнайн усаар зэс саванд 100 дахин угааж цэвэршүүлэн зандан модны охь тос нэмж өгсөн эмчилгээний чанартай гайхамшигт бүтээгдэхүүн юм.

Бүтээгдэхүүний онцлог

100 дахин угаасан шар тос нь цэвэр амин дэм, өөх төс, уургаар баялаг хамгийн шим тэжээлтэй биологийн бүтээгдэхүүн бөгөөд арьсны гэмтсэн эд эсийг эдгээж, бэхжүүлэх, шим тэжээлийг арьсны гүнд шингээж өгөх чадвартай юм.

Энэхүү тосыг тогтмол хэрэглэснээр арьсаа залуу хэвээр нь удаан хадгалж чадах ба нүүрээ химийн хортой будаг шунхаар будах шаардлагагүй болно. Таны арьс нялх хүүхдийн мэт зөөлөн, булбарай, чийглэг, илүү амьд байгалийн торгомсог бүтэцтэй болох болно.

Үрчлээ тэнийн толигор болж, сэвх нөсөө бүдгэрнэ. Шар тосыг зэс саванд сарнайн усаар угааж цэвэршүүлэн, зандан модны охь тос нэмж өгсөн нь эмчилгээний өндөр ач холбогдолтой бөгөөд арьсыг тайвшруулж, сэргээж, үрэвсэл, харшил өгөхөөс хамгаална.

Элдэв химийн бодисын орц найрлагагүй, үнэргүй, парабен болон хорт хавдар үүсгэгч бодисоос ангид цэвэр байгалийн бүтээгдэхүүн гэдгээрээ онцлог юм.

100 дахин угаасан шар тос 100% аюулгүй. Бүх насны хүүхэд, жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүд, ахмад настан, дархлаа султай, дааврын өөрчлөлттэй хүмүүс хэрэглэхэд аюулгүй.



Гэр бүлийн бүх гишүүд, бүх насны хүмүүст тохирсон хамгийн эрүүл чийгшүүлэгч, тэжээл юм. Сна, массажны зориулалтаар хэрэглэж болно. Ямар ч илүүдэл тос үлдэхгүйгээр арьсны 7 давхаргад гүн шингэж өгдөг зөөлөн, хөнгөн бүтэцтэй тос юм.



БИЕЙН МАССАЖНЫ ТОС

Хий махбод болон хийн арьс гэж юу вэ?

Хий махбод нь огторгуй, хийн эрчим хүчний хослол юм. Хийн тэнцвэр алдагдахад бидний арьс хуурай, ширүүн, үхмэл өнгөгүй болж амархан үрчлээ үүсдэг.



ХИЙГ ТЭНЦВЭРЖҮҮЛЭХ БИЕЙГ ТОС

Ургамлын гаралтай биеийн тос нь биеийн гаднах эд эсийг эрүүлжүүлж, өнгийг сэргээх зайлшгүй шаардлагатай арьс арчилгааны бүтээгдэхүүн юм. Арьстай ижил молекул нягтралтай эдгээр цэвэр ургамлын тос нь арьсны бүх давхаргад нэвтэрч тэжээл өгөн чийгшүүлж, үйл ажиллагааг сайжруулдаг.



Найрлага:

Суурь тос: Жожоба,
чидун жимс, гүнжид, авокадо,
маалинга, витамин E
Эфирийн тос: Сэдарвүүд,
лавандэр, лотус, ганга

ШАРЫГ ТЭНЦВЭРЖҮҮЛЭХ БИЕЙН ТОС

Сарнай, мэлрэг цэцгийн цэвэр эфирийн тос бүхий зандан мод, арур зэрэг нөхөн сэргээгч ургамлын хольцыг агуулсан энэхүү сэрүүн найрлага нь арьсны эсийг тэнцвэржүүлж тайвшруулдаг. Цусны эргэлтийг сайжруулан арьсны эдийг бэхжүүлж, эсийг тэжээлээр хангадаг тул бүх биедээ жигд түрхээрэй.

Энэхүү олон үйлдэлт найрлага нь массаж хийхэд тохиромжтой биеийн тос бөгөөд холимог болон эмзэг арьсанд тохиромжтой юм.

Мөн ванны тос, нүүрний цэгүүдэд массаж хийх, нүүр будалтыг арилгахад ашиглаж болох байгалийн эрүүл тосны холимог юм.

Энэхүү ургамлын гаралтай биеийн тос нь биеийн гаднах эд эсийг эрүүлжүүлэх, гэрэлтүүлэхэд зайлшгүй шаардлагатай арьс арчилгааны бүтээгдэхүүн юм.





Суурь тос: Наргил, чидун жимс, жожоба, наранцэцэг, авокадо, витамин Е

Эфирийн тос: Сэдарвүүд, лавандэр, жасмин, пеперминт



Арьстай төстэй молекулын нягтралтай эдгээр цэвэр, ургамлын гаралтай биеийн тос нь арьсны бүх 7 давхаргад нэвтэрч, арьсыг тэжээж, чийгшүүлж, үйл ажиллагааг сайжруулдаг амин чухал тэжээлээр хангана. Цэвэр, ургамлын гаралтай тосыг биедээ түрхэх нь Аюурведад нандигнан, цаг үеэ олсон зан үйл юм. Хайр гэсэн утгатай санскрит үг болох снеха нь Аюурведийн олеацын зан үйл болох снеханагаас гаралтай нь санамсаргүй хэрэг биш юм.

БАДГАНЫГ ТЭНЦВЭРЖҮҮЛЭХ БИЕЙН ТОС



Суурь тос: Бүйлс, усан үзэм, шар буурцаг, витамин E
Эфирийн тос: Цагаан гаа, жүрж, кардамом, лемонграсс,
эвкалиптус



ХАЧ ГҮРГҮМТЭЙ ЗОВХИНЙ ТЭЖЭЭЛИЙН ТОС



Найрлага: Сарлагийн шар тос,
усан үзмийн тос, жожоба тос, хач
гүргүм, витамин E

Энэхүү тосны найрлагад буй олон
төрлийн ашиг тустай улаан алт гэгддэг
хач гүргэм нь нүдний доод зовхий арьсыг
тэжээлээр хангаж, гэрэлтсэн өнгөлөг
болгоход тусалдаг.

Мөн нүдний эргэн тойрон дах хар хүрээг
бүдэгрүүлж хягасан үрчлээг багасгаж өгөх тусгайлан
найруулсан органик тэжээл юм.

АРЬС АРЧИЛГААНЫ УРГАМЛЫН НУНТАГ



Найрлага: Овьёос, улаан сэвэг зарам, ногоон вандуй, улаан будаа, турмерик, сарнай, зандан мод, чихэр өвс, хач гүргүм, бүйлс самар, кокосын сүү, витамин E

Яагаад эмийн ургамлаар арьсаа арчлах ёстой вэ?

Нүүр нь хүний биеийн болон сэтгэлийн өвөрмөц онцлогийг илэрхийлдэг хамгийн чухал хэсэг юм.

Бүх таван мэдрэхүйн эрхтэн нүүрэн дээр байрладаг бөгөөд энэ нь амьдралын бүхий туршлага, сайн мууг мэдрэхэд тусалдаг.

Нүүр бол хүний дотоод бие бялдар, сэтгэл санаа, сэтгэцийн эрүүл мэндийг тусгах толь юм. Заримдаа нүүрний дохио зангаа нь харилцаа, өөрийгөө илэрхийлэх хамгийн сайн арга хэрэглэгдэхүүн болдог юм.

Уламжлалт анагаах ухааны онолоор бидний нүүр нь маш зөөлөн, эмзэг энергийг илэрхийлдэг биеийн БАДГАН- ы бүсэд байрладаг хэсэг юм. Биеийн бусад хэсгүүдтэй харьцуулахад маш зөөлөн бөгөөд онцгой анхаарал халамж шаардагддаг, хамгийн сайн байгалийн гаралтай бүтээгдэхүүнийг эрэлхийлдэг арьс буюу эрхтэн юм. Гэхдээ худалдаанд байдаг ихэнх байгалийн гаралтай гэх бүтээгдэхүүнүүд нь химийн хорт бодис, нэмэлт бодисоос бүрэн ангид байж чаддаггүй.

Харин Арура брэндийн энэхүү бүтээгдэхүүн нь эмийн болон хүнсэнд хэрэглэдэг ургамал ногоонуудаас бүтсэн учраас 100% органик бөгөөд нүүрний эд эсийг чангалж, тэжээж, сэргээхэд тусална.

Таны арьсыг байгалийн энергиэр сэргээж гөлгөр, гялалзсан болгоно. Мөн цэвэрлэгч ургамлын нунтаг дах сарнай, турмерик, зандан мод, цагаан гаа зэрэг найрлагууд нь бүх төрлийн арьсанд тохирох бөгөөд ариутгах үйлчилгээтэй залуужуулах эмийн тусгай хольц юм. Үүнийг өдөр бүр хэрэглэхэд нүүрний арьсны pH-ийн тэнцвэрийг зөвөөр хадгалахад тусална.

Энэхүү ургамлын нунтгийг хэрэглэж байгаа үед та нүүрээ цэвэрлэхдээ ямар ч саван түрхэх шаардлагагүй.

Үүнийг та арьсны төрөлдөө тохируулан зөгийн бал, сүү, тос, тараг, устай хольж нүүрний маск, цэвэрлэгч зэрэг аль хэлбэрээр хэрэглэж болно.



ХӨГШРӨЛТИЙН ЭСРЭГ MASK

100% органик, ургамлын орц найрлагатай хөгшрөлтийн эсрэг маск нь арьсанд тэжээл өгч, өнгийг сэргээн, сэвх нөсөөг арилгаж цайруулах ба батга, үрэвслийн эсрэг нөлөө үзүүлнэ.



Найрлага: Хач гүргүм, зандан мод, задь, чихэр өвс, шинц модны холтос, агар модны охь тос, витамин E, зөгийн бал



УРГАМЛЫН САВАН

Манай брэнд сүү, зандан мод, шар гаа, гүргүм өвсний найрлагатай эмчилгээний саванг таны хэрэглээнд нэвтрүүлж байна.

Энэхүү бүтээгдэхүүн нь байгаль орчны хатуу нөхцлөөс арьсыг хамгаалж чадах ургамлын гоо сайхны саван юм.

Савангийн найрлагад байгаа шар гаа нь бактерийн эсрэг шинж чанартай байдаг. Зандан мод нь ариутгах, халдваргүйжүүлэх, үрэвсэл дарах үйлчилгээтэй. Гүргүм өвс нь арьсыг эрчимтэй нөхөн төлжүүлж, цэвэршүүлж, сорви толбыг арилгаж өгдөг. Сүү нь чийгшүүлж, тэжээлээр хангах үйлчилгээтэй.

Энэхүү саван нь дээд зэргийн үнэт ургамал болох гүргүм өвс, зандан модны найрлагатай гэдгээрээ өвөрмөц юм.

“НОРОВ” БАННЫ ДАВС



*Найрлага: Жамц давс,
арур, барур, жүрүр,
мана, лидэр, гандигар,
хонин арц, агь, даль*

Эмийн ургамлын
холимог бүхий энхүү
давс нь хөл болон бүтэн
биеийн ваннанд ороход
тохиромжтой. Булчингийн
өвдөлт, хөшүүн байдал,
экзем, арьсны өвчин, үе
мөчний үрэвсэл, тулай,
судас мэдрэлийн өвчнийг
намдаах үйлчилгээтэй.
Арьсны өнгийг гэрэлтүүлж,
хор тайлах, сэтгэлийн
түгшүүр, стрессийг
бууруулж биеийн алжаал
ядаргааг тайлах нөлөөтэй.

“ШҮДНИЙ ОТОЧ”

Амны хөндийн
арчилгааны
ургамлын нунтаг



100% байгалийн эмийн ургамлаар хийсэн энэхүү нунтаг нь шүдийг бэхжүүлж, унах эрсдлээс хамгаална. Өнгийг сэргээж, цайруулах ба шүд хорхойтох, чулуу үүсэх, буйлнаас цус гарах болон бусад амны хөндийн үрэвсэлт өвчнөөс хамгаална. Шүд өвдсөн үед өвдөлт намдаана. 24 цагийн турш таны шүд, амны хөндийд нян бактер үржихээс хамгаална. Ялангуяа хүүхдийн шүд цоорох эмгэгээс урьдчилан сэргийлж, эрүүлжүүлнэ. Бүх насны хүмүүс хэрэглэхэд тохиромжтой.



Найрлага: Жамц давс, шинц модны холтос, ногоон сүгмэл, хадаасан цэцэг, задь, чихэр өвс, арур, барур, жүрүр, жонш, хар гүгүл, хар чинжүү, хуш модны нүүрс, гавар, зөгийн бал

“ҮСНИЙ ОТОЧ”

Ургамлын хандтай үсний тэжээлийн тос

Үс уналт нь хүмүүсийн хамгийн том эмзэг асуудлын нэг байдаг. Үс уналт явагдах нь бидний өөртөө сэтгэл хангалуун байх байдлыг бууруулдаг. Энэ нь ажлын хэт ачаалал, нойргүйдэл, буруу хооллолт болон үсээ буруу арчилснаас болж үүсдэг. Иймээс бид үс уналтаас сэргийлэх бүтээгдэхүүнийг таны гарт хүргэж байна.

100% цэвэр ургамлын ханд агуулах энэхүү тос нь үсийг эрүүл, гялалзсан бат бөх байлгахад туслах юм. Хуйхыг эрүүлжүүлж, үсний угийг эмчилнэ.





УРГАМЛЫН ШАМПУНЬ

Урт, өтгөн, гялалзсан эрүүл үс бол эрт дээр үеэс эхлэн эмэгтэйчүүдийн гоо үзэсгэлэнгийн хамгийн тансаг хөрөнгө гэж үнэлэгдэж ирсэн.

Ургамлын шампунь нь хуйхны халдвараас сэргийлж, үсийг тэжээлээр хангаж, нөхөн сэргээдэг. Химийн орц найрлагатай, синтетик шампуньтай харьцуулахад ямар ч хор нөлөө байхгүй. Үсний гэмтлийг арилгаж, уналтаас сэргийлдэг. Үсэнд тэжээл өгч, хуйхыг цэвэрлэх ба цусны эргэлтийг сайжруулж үсийг бэхжүүлнэ. Үс болон хуйхны тослогийг алдагдуулахгүйгээр зөөлнөөр цэвэрлэж өнгийг сэргээж гялалзуулна. Үс хуурайших, унах, цайрах зэргээс хамгаална.



Найрлага: Савангийн самар, жүрүр, шикакай

Бидний бүтээсэн цэвэр байгалийн гаралтай шампунь нь химийн гаралтай бодис, өтгөрүүлэгч, зөөлрүүлэгч силикон агуулаагүй учир нярай хүүхэд, арьсны харшилтай, жирэмсэн, химийн тарианы болон стрессээс үүдэлтэй үс уналт, шингэн, салаалж гэмтсэн үстэй бүх насны хүмүүст тохиромжтой бүтээгдэхүүн юм.

ШИКАКАЙ



Шикакай гэдэг нь “үсэнд зориулсан жимс” гэсэн утгатай. Энэхүү ургамал нь маш сайн цэвэрлэгч, үс хуйхны тослогийн тэнцвэрийг хадгалж өгдөг юм. Ялангуяа эмзэг мэдрэмтгий хуйханд маш сайн зохицох бөгөөд үсний ургалтыг дэмжиж, үсний угийг бэхжүүлнэ.

САВАНГИЙН САМАР



Үүнийг саван болон шампунийн үндсэн орц болгон ашигладаг. Мөөгөнцрийн эсрэг үйлчилгээтэй учраас үс хагталтыг эмчилдэг. Үрэвсэл халдварын эсрэг чанартай тул янз бүрийн амьтан хазсан арьсны эмзэгшилд түрхэж болно.

Эрдэмтэд савангийн самрыг антиоксидант, үрэвслийн эсрэг, бактерийн эсрэг, өвдөлт намдаах, халуун бууруулах шинж чанартай гэж тогтоосон байдаг.

ЖҮРҮР



Жүрүр нь антиоксидант чанартай бөгөөд төмөр дутлыг нөхдөг витамин С-ийн баялаг эх үүсвэр юм. Үсний уутанцрын үхжсэн эсийг шинэ эсээр солиход тусалдаг. Үсний ургалтыг дэмжиж, коллаген уургийн нийлэгжилтийг өдөөж өгдөг. Гадны утаа, тоос шороо, бохирдолоос хамгаалдаг.



ӨДӨР ТУТМЫН ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН





УРГАМЛЫН ЭМЧИЛГЭЭНИЙ ДЭР

Эмчилгээний дэр нь шар будаа, сагагийн хальс, ногоон цай, лишь цэцэг, гүргүм өвс, лавандар, канфор, арц, задь, кассиа үр, гааны навч зэрэг 15 төрлийн эмийн ургамлын орц найрлагатай тул анхилам зөөлөн үнэртэй.

Энэхүү дэр нь тархины цусан хангамж сайжруулах, толгойн өвдөлт намдаах, бат бөх унтаж амрахад туслах ба зөв хэлбэртэй учраас нуруу хүзүүний нугаламд ирэх ачааллыг бууруулж, хүзүү шохойжих, суулт муруйлт үүсэх, булчин чангарах эрсдлээс урьдчилан сэргийлнэ.

НЯРАЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ДЭР

Кассиа үр, шар будааны хальсаар хийсэн энэхүү дэр нь цусны эргэлтийг сайжруулж, хүүхдийн тархины даралтыг бууруулж, унтаж байх үед нь толгой, хүзүүнд массаж болж өгдөг бөгөөд энэ нь тархи мэдрэлийг амраах нөлөө үзүүлснээр дотоод эрхтний үйл ажиллагааг сайжруулахад тусалдаг. Кассиа үр нь сэрүүн шинж чанартай учир зуны халуун өдрүүдэд хэрэглэхэд илүү тухтай байдаг.



ДАВСАН ЖИН

100% байгалийн үр тариа, жамц давс, анхилам үнэрт ургамлууд, эфирийн тосны найрлагатай богино долгионы зууханд халааж хэрэглэхэд тохиромжтой эмчилгээний жинг таны хэрэглээнд зориулж байна.

Бүтээгдэхүүний онцлог

- » Цэвэр даавуун материал
- » Химийн орц найрлагагүй, аюулгүй
- » Халааж, хөргөж хэрэглэхэд тохиромжтой
- » Спорт клуб, фитнес төв, сургууль, цэцэрлэг, оффис, үйлдвэрийн газарт анхан шатны тусламж үзүүлэх буюу өвчин намдаах зорилгоор хэрэглэж болно
- » Бүх насны хүмүүс хэрэглэх боломжтой



Эрүүл мэндийн ашиг тус

1. Цусны эргэлтийг сайжруулна
2. Ядарч цуцсан, чангарсан булчинг суллаж амраана
3. Үе мөч, нуруу, сарын тэмдгийн өвдөлт намдаана
4. Стресс ядаргааг тайлна
5. Хэвлий, давсагны хий дүүрэнгийг арилгана
6. Хоолны шингэцийг сайжруулна
7. Эрэгтэйчүүдийн түрүү булчирхайн шохойжилт, бэлгийн сулрал, бөөр давсагны хүйтэн хийн өвчнийг анагаана
8. Нойргүйдлийг анагаана
9. Суулгалт, бөөлжилтийг зогсооно



*Найрлага: Задь, арвай, кумин, гүнжидийн
үр, хадаасан цэцэг, цагаан гаа*

“МОНГОЛ ТӨӨНӨ” СТРЕСС ТАЙЛАХ УРГАМЛЫН ТОСОН ТӨӨНҮҮР

Энэхүү ургамлын бөмбөлгийг стресс тайлах цэгүүдийг халааж биед хуримтлагдсан энергийг түгжээг арилгахад ашиглана.

Энэ бол Монголчууд бидний өвөг дээдсээс уламжлан ирсэн эмчилгээний арга, хэрэглэгдэхүүн юм.

Арура органикс брэнд энэхүү эмчилгээг орчин үеийн эмчилгээний хэлбэрт оруулан өөрчилж та бүхний хэрэглээнд нэвтрүүлж байна. Биед стрессээс үүссэн сэтгэлийн хямрал, нойргүйдэл, шалтгаангүй сэтгэл гутрал, тайван бус байх, үе мөч хөших, толгой эргэх, хүзүү мөр хөших, зүрх уушиг хүнд оргих, хий юм харах, чих шуугих зэрэг зовиурын үед хэрэглэж болох бие махбод, сэтгэл санааг тайвшруулах энгийн бөгөөд үр дүнтэй эмчилгээний хэрэгсэл юм. Ургамлын бөмбөлгөнд тос нэвчүүлж богино долгионы зууханд халаан стрессийн 5 цэг болох толгойн орой, 2 гарын алга, хөлийн уланд тус бүр 5 минут жин тавьж халааж, цэгүүдийг үрж, иллэг хийх маягаар ашиглана. Мөн бусад хий, мэдрэлийн цэгүүдэд эмчийн заавраар хэрэглэж болно.

Бид таны хэрэглээнд нийцүүлэн хүүхэд болон насанд хүрэгчид хэрэглэж болохоор том, жижиг савалгаатайгаар үйлдвэрлэж байна.

“ЖАМЗИ” ЭМЧИЛГЭЭНИЙ БАГЦ

Уламжлалт анагаах ухаанд хийн тэнцвэргүй байдал бүх өвчний шалтгааны 80%-ийг эзэлдэг гэж үздэг. Хий нь бодисын солилцооны илүүдэл ялгас (хөлс, шээс, өтгөн гэх мэт)-ыг гадагшлуулах, биеийн эрүүл байдал, хөдөлгөөнийг хянах ерөнхий үйлдэлтэй. Түүнээс гадна бүдүүн гэдэсний салст бүрхэвч нь ясны эдтэй холбоотой байдаг учраас бүдүүн гэдсээр хийсэн ургамлын ханд нь ясыг дотроос нь тэжээж бэхжүүлж өгдөг.

Бид бүдүүн гэдсэн дэх хийн тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн тусгай жороор бэлтгэсэн тосон эм бүхий эмчилгээний багц бүрдлийг танд зориулж байна.

Багц

1. Ургамлын ханд бүхий тосон эм
2. Нэг удаагийн бургуйны сав

Ашиг тус:

- » Хийн бүх төрлийн эмгэг, тэнцвэргүй байдлыг эмчилнэ.
- » Дархлаа сайжирна.
- » Эд эсийг тэжээлээр хангах ба ялангуяа ясны эдийг бэхжүүлнэ.
- » Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг нэмэгдүүлж өтгөн хатахаас сэргийлнэ.
- » Бие хүйт оргих зовиурыг намдаана.
- » Бөөр нурууны эмгэгээс сэргийлнэ.
- » Хэрэх, тулай зэрэг үе мөчний өвчнийг эмчилнэ.
- » Бэлгийн чалх, тамир хүчийг сайжруулна.



“НИРУХА” ЭМЧИЛГЭЭНИЙ БҮРДЭЛ

Нируха нь нарийн бүдүүн гэдсээр маш хурдан хугацааны цэвэрлэгээ хийх арга юм.

Энэхүү эмчилгээг хийхээсээ өмнө заавал мэргэжлийн эмчээс зөвлөгөө авч өөрт тохирох эсэхийг тодруулаарай.



Багц:

1. Хоргүйжүүлэх ургамлын нунтаг
2. Нэг удаагийн бургуйны уут

Ашиг тус:

- » Биед хуримтлагдсан хорыг гадагшлуулна.
- » Жингийн алдагдлыг нөхнө.
- » Илүүдэл жинг бууруулна.
- » Нүдэнд тэжээл өгнө.
- » Хөгшрөлтийн явцыг удаашруулна.
- » Арьсны өнгийг сэргээнэ.
- » Дархлаа дэмжинэ.



УРГАМЛЫН ҮНЭРТ УУТ

Орчин үед стресс, агаарын бохирдлоос үүсэлтэй маш олон өвчин зовиур илрэх болсон. Тухайлбал харшил, хамар битүүрэх, толгой эргэх, тайван бус болох гэх мэт

Бид эдгээр зовиурыг багасгах үнэрт ургамлыг, цэвэр ургамлын тосны охьтой хоршуулж танд хүргэж байна.

Та шинэхэн цэвэр ургамлын үнэрээр нэг удаа л амьсгалахад таны сэтгэл бие махбод сэргэх болно.

Ургамал болон үнэрт тосны хослол нь танд эрч хүчийг бэлэглэх болно.



ҮНЭРТ УРГАМЛЫН ТҮРХЛЭГ

Та анхилуун үнэрээр үзэсгэлэнтэй, эрүүл байдлаа удаан хадгалахыг хүсвэл бидний зохион бүтээсэн үнэрт түрхлэгийг хэрэглээрэй.

Парабен, эрдэст тос, алкоголь, синтетик өнгө, хиймэл үнэр агуулаагүй 100% байгалийн цэвэр бүтээгдэхүүн.

Таны сэтгэл хөдлөлийг тэнцвэржүүлж, сэтгэл гутралаас сэргийлэх, ажлын стрэссийг бууруулах, арьсны үрэвсэл цочрол, шавьж шумуул хазахаас сэргийлэх ба таныг тав тухтай бат бөх унтахад тусалж булчингийн өвдөлт чангаралыг багасгах нөлөөтэй.







samandbadraa@mongol.net



Samandbadraa traditional medical clinic



+976 77142525